

## ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

### ОРШИЛ

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2 дахь хэсгийг “...Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ...” гэж өөрчлөн хуульчилсан билээ. Үүний дагуу Уул уурхай хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-наас “Үндэсний баялгийн сангийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулсан байна.

Бусад улс орны туршлагаас үзэхэд тухайн улс орны үндэсний хөгжлийн стратеги, эдийн засгийн бүтэц болон хөгжлийн үе шатаас хамаарч баялгийн сангийн зорилго, институцийн тогтолцоо болон хөрөнгө оруулалтын зорилго нь харилцан адилгүй байна. Гэхдээ улс орнууд үндэсний баялгийн сангийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, практик буюу «Сантьягогийн зарчим»-ыг<sup>1</sup> харгалзан хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд дээрх зарчмуудад нийцүүлэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг (цаашид “Баялгийн сан” гэх) оновчтой боловсруулан хэрэгжүүлснээр хөгжлийн стратеги, урт хугацааны тогтвортой хөгжлийг тэтгэсэн эдийн засгийн бүтэц бий болгох, улмаар газрын хэвлий дэх байгалийн баялгийг зөв ашиглах, түүний үр өгөөжийг хөрөнгө оруулалтын зөв бодлого хэрэгжүүлэн байршуулах замаар хойч үедээ үлдээх боломж бүрдэх юм. Иймд Нээлттэй Нийгэм форумын дэргэдэх Төсвийн зөвлөлөөс тус хуулийн төслийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэн доорх санал, шүүмжийг боловсруулан хүргүүлж байна.

Энэхүү санал, шүүмжийг боловсруулахад баялгийн сангийн олон улсын туршлага, нийтлэг зарчим, хууль тогтоомжийн уялдаа холбоо, зохицуулалтгүй үлдээсэн харилцаа зэргийг шалгуур болгон (i) Хууль эрх зүйн орчин, зорилго, макро эдийн засгийн уялдаа холбоо; (ii) Институцийн тогтолцоо ба засаглалын бүтэц; (iii) Хөрөнгө оруулалт ба эрсдэлийн удирдлагын тогтолцоо гэсэн гурван үндсэн чиглэлээр ерөнхий болон тусгай санал шүүмж боловсрууллаа. Үүнд:

<sup>1</sup> Сантьягогийн зарчим “Нийтээр зөвшөөрсөн зарчим, практик”-ийг [https://www.ifswf.org/sites/default/files/santiagoprinciples\\_0\\_0.pdf](https://www.ifswf.org/sites/default/files/santiagoprinciples_0_0.pdf) цахим хуудаснаас үзнэ үү.

## ЕРӨНХИЙ САНАЛ ШҮҮМЖ

### I. Хууль эрх зүйн орчин, зорилго, макро эдийн засгийн уялдаа холбоо

*Баялгийн сан болон түүний төрөл, тэдгээрийн зорилго чиг үүргийг оновчтой тодорхойлох*

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д хуулийн зорилгыг “...үндэсний баялгийн сангийн төрлийг тогтоож, тус сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд баримтлах нийтлэг зарчим, сангийн тайлагнал, ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна...” гэж тодорхойлсон хэдий ч төслийн холбогдох зүйл, заалтууд нь дээрх зорилгыг хангахуйц биш, маш ерөнхий тойм байдлаар томъёологдон, хэтэрхий товч буюу есөн зүйлд багтсан байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хууль нь энэ төрлийн харилцааг зохицуулах суурь хууль болохын хувьд баялгийн санд баримталж буй төрийн бодлого, баялгийн санг бүрдүүлэгч бусад санд баримтлах нийтлэг зарчим, баялгийн сангийн үйл ажиллагааны үндсэн механизм, баялгийн сангийн эрх зүйн байдал зэрэг зарчмын шинжтэй гол зохицуулалтыг заавал тусгасан байх шаардлагатай. Тухайлбал, Сантьягогийн зарчмын 1-д “Үндэсний баялгийн сан нь бие даасан хуультай байх шаардлагатай ба хууль тогтоомжийн зохицуулалт нь сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах, сан зорилгоо биелүүлэх боломж нөхцөлийг дэмжсэн байх шаардлагатай” гэж тусгасан байдаг.

**Санал:** Хуулийн төслийн зорилготой уялдуулан сангийн тайлагнал, ил тод байдал, хариуцлага, хөрөнгийн удирдлагад тавигдах шаардлага зэрэг хуулийн төсөлд одоогоор тодорхой бус байгаа сайн засаглалын шаардлагуудыг тодорхой болгох.

Бусад улсын туршлагаас судлан үзэхэд баялгийн сан нь хуримтлалын, хөрөнгө оруулалтын, хуваарилалтын гэсэн зорилгын хүрээнд үндсэн чиг үүргээ гүйцэтгэж байна. Гэхдээ зарчмын хувьд эрс тэс ялгаатай зорилтын улмаас дээрх гурван зорилгыг нэг сан нэгэн зэрэг хэрэгжүүлж чаддаггүй байна. Тухайлбал, а) хуримтлал, хөрөнгө оруулалтын чиг үүргийг нэг сан хэрэгжүүлэх; б) хөрөнгө оруулалт, хуваарилалтын чиг үүргийг мөн нэг сан хамтад нь хэрэгжүүлж болдог. Харин хуримтлал болон хуваарилалтын чиг үүргийг нэг сан хэрэгжүүлэх боломжгүй. Үүнийг Чили, Норвег, Катар, Сингапур зэрэг улсын сангуудын жишээн дээрээс харж болно.

Гэтэл манайд УИХ-аас баялгийн сантай холбоотой бодлогын шинжтэй хоёр тогтоол гаргасан байдаг. Эхнийх нь буюу 2020 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 23 дугаар тогтоолын 4.6-д “баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ” гэж тусгажээ. Мөн 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай” 56 дугаар тогтоолд “баялгийн сангийн тухай хуулийн төслийг батлуулж хэрэгжүүлнэ”, мөн “баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг өнөө болон ирээдүй хойч үедээ тэгш шударга хүртээнэ” гэж заажээ. Үүнээс дүгнэхэд баялгийн сан нь хөрөнгө оруулалт хийх, тэгш шударга хуваарилах гэсэн ялгаатай чиг үүргүүдийг нэгэн зэрэг хэрэгжүүлэхээр ойлгогдож байна.

Хуримтлал, хөрөнгө оруулалт, хуваарилалт гэсэн чиг үүргийг нэг сангаар дамжуулан шийдэх нь төвөгтэй бөгөөд энэ гурван зорилгыг бүгдийг нь нэг хуульд багтаах ч бас боломжгүй юм. Иймд нэн түрүүнд энэхүү гурван чиг үүргийн ялгааг бодлого боловсруулагчдын түвшинд буюу Засгийн газар, УУХҮЯ болон Сангийн яам хамтран хэлэлцэж, баялгийн сан болон түүний төрлүүдийн чиглэл, зорилго, гүйцэтгэх үүргийн талаар нэгдсэн байр сууриа тодорхой болгох хэрэгтэй байна.

#### Санал:

- Баялгийн сангийн аль төрөл, чиглэлийг тэргүүн ээлжид хөгжүүлэх талаарх төрийн бодлогыг тодорхой болгох;
- Баялгийн сангийн төрлийг төрийн бодлого, макро эдийн засагт үзүүлэх нөлөө болон түүнтэй холбоотойгоор хэрэгжүүлэх хөрөнгийн удирдлагын бодлого зэрэгтэй уялдуулан оновчтой тодорхойлох;
- Баялгийн сангийн эрх зүйн байдал, зорилго болон макро эдийн засгийн уялдаа холбоог Ирээдүйн өв сангийн тухай хууль, Хөгжлийн сангийн хуулийн төслийн зохицуулалттай уялдуулан тодорхойлох;
- Монгол Улсын Үндсэн хуульд “газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж заасныг хэрэгжүүлэхийн тулд баялгийн сангийн бүрдүүлэгч сангуудын төрөл болон зорилгыг тус тусад нь салгаж зохицуулах;
- Үндэсний баялгийн сангийн тухай хуульд тусгах үндсэн зарчим, суурь зохицуулалтыг тодорхойлохдоо олон улсад хүлээн зөвшөөрсөн баялгийн санд тавигддаг нийтлэг зарчим, шаардлага, чиг хандлагыг харгалзан үзэх.

#### *Үндэсний баялгийн сангийн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээг тодорхой болгох*

Баялгийн сангийн бие даасан тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор зарим хууль тогтоомжийн үйлчлэлийг хязгаарлах шаардлага гарч болох юм. Сантьягогийн зарчим болон бусад орны туршлагаас харахад баялгийн сангийн мөнгөн хөрөнгө нь засгийн газрын эзэмшилд байх<sup>2</sup> бөгөөд түүнийг хөрөнгө оруулалтын арга хэрэгслээр өсгөн арвижуулах шаардлагын үүднээс зарим хууль тогтоомжийг баялгийн санд хамаарахгүй байхаар зохицуулдаг. Иймд баялгийн сангийн үйл ажиллагааг хангахтай холбоотой зарим хуулийн хамаарлыг тогтоох шаардлагатай юм. Тухайлбал, баялгийн сангийн үйл ажиллагаанд Засгийн газрын тусгай сангийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиуд үйлчлэхгүй байхаар зохицуулж болох юм.

Дээрх хуулиудыг баялгийн сангийн зохицуулалтын гадна үлдээх нь Үндсэн хууль болон салбар хуулиудын зөрчилд тооцогдохгүй. Харин үүнээс үүдэх зарим сөрөг үр дагавар буюу сангийн мөнгөн хөрөнгийг үр ашиггүй удирдах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд хуулийн төсөлд сангийн мөнгөн хөрөнгийг

<sup>2</sup> Sovereign wealth funds, Generally accepted principles and practices Santiago principles, p. 3.

зарцуулах үйл ажиллагаанд тавих хориглолт, хяналтын механизм, хөрөнгийн удирдлагын мандат, тайлагналын ил тод байдал, толгой болон охин компанийн хяналтын тогтолцоог нарийвчлан зохицуулах шаардлагатай.

**Санал:** Хуулийн төслийн 3 дугаар зүйл буюу Хуулийн үйлчлэх хүрээ гэсэн хэсэгт үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаанд хамаарахгүй хууль тогтоомжуудыг тодорхой дурдах.

## II. Институцийн тогтолцоо ба засаглалын бүтэц

Баялгийн сан нь институцийн хувьд ямар тогтолцоотой байх, үйл ажиллагаагаа хэрхэн явуулах, хяналтыг хэн хэрэгжүүлэх зэрэг асуудлууд тодорхой бус байна.

Баялгийн сангийн удирдлага, засаглалын харилцааг тодорхойлох нарийвчилсан зохицуулалт хуулийн төсөлд тусаагүй байна.

**Санал:**

- Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн эрх эрх зүйн байдлыг хуулийн төсөлд дэлгэрэнгүй тусгах;
- ТУЗ гишүүдийг сонгох, ажиллах хугацааг сунгах үйл явцыг тодорхой болгох;
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох үйл явцыг журмаар зохицуулах нь агуулгын хувьд хуультай зөрчилдсөн журам гарах улмаар сангийн удирдлага, засаглалын асуудлыг хуулиар бус харин эрх мэдэлтний хэмжээнд шийддэг болох эрсдэл дагуулж байна. Иймд хуулийг дагалдан гарах журмыг хуулийн төсөлтэй хамт өргөн барьж УИХ-аар хэлэлцүүлэх эсхүл сангийн удирдлага, засаглалтай холбоотой гол зарчмуудыг нь хуульд өөрт нь суулгаж өгөх.

Одоо үйл ажиллагаа явуулж байгаа Тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв сангийн удирдлагын хэлбэр нэг нэгнээсээ ялгаатай байдаг. Гэхдээ үйл ажиллагааны чиглэл нь зарим талаараа давхацсан байна.

**Санал:**

- Тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан, Хөгжлийн сангийн уялдаа холбоо, нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг хангах зохицуулалт бий болгох;
- Дээрх сангуудын үйл ажиллагаа Үндэсний баялгийн сантай хэрхэн уялдах, тэдгээрт хяналт тавих, ил тод байдлыг нь хэрхэн хангахыг илүү нарийвчлан зохицуулах.

### III. Хөрөнгө оруулалт ба эрсдэлийн удирдлагын тогтолцоо

#### *Баялгийн сан, түүнийг бүрдүүлэгч сангуудын орлогын эх үүсвэрийн уялдаа холбоо*

Хуулийн төсөлд тогтворжуулалтын сан буюу “төсвийн тогтворжуулалтын сан”-г баялгийн сангийн төрөлд багтаагаагүй. Энэ тохиолдолд тус сангийн эх үүсвэр болох байгалийн баялгийн орлого нь бусад сангийн орлогын эх үүсвэрээс ямар ялгаатайг тодорхойлох шаардлагатай. Учир нь Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан нь мөн л байгалийн баялгийн орлогоос санхүүжихээр байна.

#### Санал:

- Ирээдүйн өв сан, Тогтворжуулалтын сан, Хөгжлийн сангийн орлогын эх үүсвэрийн уялдаа холбоог хэрхэн хангах, ямар зарчим, бодлого баримтлан хуваарилахыг тодорхой болгох;
- Тогтворжуулалтын санг баялгийн сангийн нэг төрөлд тооцож, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тусдаа зохицуулагдах талаар хуулийн төсөлд тусгах.

Баялгийн сан болон түүнийг бүрдүүлэгч бусад сангийн уялдаа холбоо, үйл ажиллагаатай холбоотойгоор сангуудын мөнгөн хөрөнгийг ямар байдлаар эргэлтэд оруулах, ямар хэмжээний хуримтлал бий болох, хэрхэн хуваарилах зэрэг макро эдийн засгийн загвар гаргаж, сангийн мөнгөн хөрөнгийг ямар зорилгоор эргэлтэд оруулах гэх мэт бүх асуудлыг хамарсан бүрэн тооцоолол, нэгдсэн зураглал гаргах нь зүйтэй.

**Санал:** Баялгийн сангийн мөнгөн хөрөнгийн тооцоолол, нийт хуримтлагдах мөнгөн хөрөнгийн хэмжээ зэрэг макро эдийн засгийн тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад оруулах шаардлагатай.

## ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

№	Санал	Тайлбар (үндэслэл)
1	<p>Хуулийн төслийн 5 дугаар зүйлд дараах заалт нэмэх:</p> <p>5.1. “Үндэсний баялгийн сан” гэж Монгол Улсын Үндсэн хуульд заасан байгалийн баялгийг ашиглах төрийн бодлогын хүрээнд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийн зарим хэсгийг төвлөрүүлж, Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх дотоодын төсөлд санхүүгийн үр ашигтай хөрөнгө оруулалт хийх замаар хөрөнгийг арвижуулах, тогтвортой хөгжлийг хангах, бий болсон үр шимийг хуримтлуулах, улмаар хуульд заасан журмын дагуу одоо болон ирээдүй хойч үеийн иргэн бүрд тэгш шударга хүртээх зорилго бүхий санг ойлгоно.</p> <p>5.2. Үндэсний баялгийн сан нь түүнийг бүрдүүлэгч бусад сангаас бүрдэх ба дараах төрөлтэй байна:</p> <p>5.2.1. Ирээдүйн өв сан буюу хуримтлалын сан;</p> <p>5.2.2. Хөгжлийн сан буюу хөрөнгө оруулалтын сан.</p>	<p>Үндэсний баялгийн сангийн эрх зүйн байдлыг олон улсын зарчимд нийцүүлэн хуулиар заавал тодорхойлох шаардлагатай. Харин хуулийн төсөлд баялгийн санг албан ёсоор тодорхойлоогүй үлдээжээ. Сантьягогийн зарчимд “Баялгийн сан гэдэг нь засгийн газрын эзэмшилд байдаг тусгай зориулалтын хөрөнгө оруулалтын сан” гэж тодорхойлсон байдаг. Мөн “Засгийн газраас байгуулдаг баялгийн сан нь санхүүгийн зорилгодоо хүрэхийн тулд өөрийн хөрөнгийг эзэмших, удирдах, захиран зарцуулах замаар гадаад санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийж, өөрийн улсын хөрөнгө оруулалтын стратегийг хэрэгжүүлэн, макро эдийн засгийн зорилгыг хангуулна” гэж тодорхойлсон байдаг.</p> <p>Хуулийн төслийн 5 дугаар зүйлд тодорхойлсон баялгийн сангийн зорилго, үйл ажиллагаа нь зөвхөн ирээдүйн өв сангийн зорилго чиглэлд нийцсэн байна. Энэ нь Хөгжлийн сангийн зорилго, үйл ажиллагааны чиглэл нь баялгийн сангийнхтай ямар уялдаа холбоотой байхыг тодорхойгүй болгож байна.</p>
2	<p>Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3-т дараах заалт нэмэх:</p> <p>5.3. Баялгийн сан болон түүний хөрөнгө нь Монгол Улсын нийт ард түмний өмч бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг Ирээдүйн өв сан корпорац, Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг Эрдэнэс Монгол Хөгжлийн Сан ХХК хэрэгжүүлнэ.</p>	<p>Хуулийн төсөлд баялгийн сангийн хөрөнгө, түүний удирдлагыг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийг тодорхой болгоогүй байна. Эрх зүйн байдлын хувьд Үндэсний баялгийн сан, Ирээдүйн өв сан, Хөгжлийн санг тухайн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч (оператор буюу гүйцэтгэгч компаниуд)-ээс салгаж, ялгаатай томьёолох нь зүйтэй.</p>

№	Санал	Тайлбар (үндэслэл)
3	<p>Хуулийн төсөлд дараах зүйлийг нэмэх:</p> <p>Үндэсний баялгийн сангийн зөвлөл</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Баялгийн сан нь Монгол Улсын нийт ард түмний өмч болохын хувьд Үндэсний баялгийн сангийн зөвлөлтэй (цаашид Зөвлөл гэх) байна.</li> <li>2. Зөвлөл нь баялгийн сан болон түүнийг бүрдүүлэгч сангуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, мэдээллийн солилцоог хангах, баялгийн сан болон түүнийг бүрдүүлэгч сангуудын санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах, зөвлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.</li> <li>3. Зөвлөл нь дараах асуудлыг хэлэлцэнэ: <ol style="list-style-type: none"> <li>3.1. Баялгийн сан болон түүнийг бүрдүүлэгч сангуудын нэгдсэн төлөвлөгөө, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэлэлцэх;</li> <li>3.2. Баялгийн санг бүрдүүлэгч бусад сангийн үйл ажиллагааны тайлан, аудит хийлгэсэн санхүүгийн тайланг жил бүр хүлээн авч хэлэлцэх, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор баялгийн сангийн цахим хуудсанд байршуулах;</li> <li>3.3. Баялгийн сан болон түүнийг бүрдүүлэгч сангуудын үйл ажиллагааг сайжруулах талаар харилцан мэдээ, мэдээлэл солилцох, зөвлөмж гаргах;</li> <li>3.4. Бусад</li> </ol> </li> <li>4. Зөвлөлийн бүрэлдэхүүн <ol style="list-style-type: none"> <li>4.1. Зөвлөл нь үндсэн гишүүд болон орон тооны бус гишүүдээс бүрдэнэ.</li> <li>4.2. Зөвлөлийн үндсэн гишүүд: <ol style="list-style-type: none"> <li>4.2.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;</li> <li>4.2.2. Монголбанкны Ерөнхийлөгч;</li> <li>4.2.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;</li> <li>4.2.4. Санхүүгийн зохицуулах хорооны дарга.</li> </ol> </li> <li>4.3. Зөвлөлийн орон тооны бус гишүүд: <ol style="list-style-type: none"> <li>4.3.1. Эрдэнэс Монгол хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга;</li> <li>4.3.2. Ирээдүйн өв сан корпорацийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга;</li> <li>4.3.3. Хувийн хэвшлийн гурван төлөөлөл;</li> </ol> </li> <li>4.4. Иргэний нийгмийн байгууллагын гурван төлөөлөл.</li> </ol> </li> </ol>	<p>Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт баялгийн сангийн ил тод байдал, тайлагналыг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхой зохицуулаагүй, мөн баялгийн сан нь түүнийг бүрдүүлэгч бусад сангаасаа тусдаа буюу бие даасан байх эрх зүйн баталгааг тодорхойлж өгөөгүй байна. Баялгийн сангийн бие даасан байдал, тайлагнал, ил тод байдлыг зохистойгоор хангахын тулд сангийн дэргэд хараат бус бие даасан “Үндэсний баялгийн сангийн зөвлөл” байгуулж болох юм. Олон улсын туршлага, нийтлэг зохицуулалтыг харахад баялгийн сангийн дэргэд зөвлөх хороо эсвэл зөвлөл ажиллах байдлаар сангийн нэгдсэн бодлогыг тодорхойлж, түүний нэгдсэн төсөв, тайлагнал, ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээлэл хүргэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна.</p>

№	Санал	Тайлбар (үндэслэл)
4	<p>Хуулийн төсөлд дараах заалт нэмэх:</p> <p>1. “Баялгийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:</p> <p>0.1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ... хувь”;</p> <p>0.2. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид хамаарах хувьцааг борлуулсны орлогын ... хувь;</p> <p>0.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид хамаарах хувьцааны ногдол ашгийн ... хувь”.</p>	<p>Хуулийн төсөлд баялгийн сангийн төрлийг бүрэн тодорхойлоогүй ба тэдгээрийн хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойгүй орхисон байна. Ирээдүйн өв сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Хөгжлийн сангийн орлогын эх үүсвэрийг хэрхэн уялдаа холбоотойгоор, ямар зарчим бодлого баримтлан хуваарилах талаарх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна.</p>
5	<p>Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.2-ыг дараах байдлаар өөрчлөх:</p> <p>6.2. Үндэсний баялгийн сангийн хөрөнгийг удирдах үйл ажиллагаанд дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:</p> <p>6.2.7. Баялгийн сангийн хөрөнгөөс тэтгэлэг, урамшуулал, тусламж, дэмжлэг олгох;</p> <p>6.2.8. Баялгийн сангийн хөрөнгөөс нийгмийн халамжийн чиглэлээр бэлэн мөнгө болон бусад хэлбэрээр хөрөнгө тараах;</p> <p>5.1.9. Улсын төсвийн санхүүжилтээр хийгдэх төсөл, хөтөлбөрийг Баялгийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх;</p> <p>5.1.10. Улсын Их Хурал, төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх;</p> <p>5.1.11. Баялгийн сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсанаас бусад аливаа хэлбэрээр ашиглах, бусдад шилжүүлэх;</p> <p>5.1.12. Баялгийн сангийн хөрөнгийг аливаа хэлбэрээр улсын төсвийн бүрдэлд багтаах, нөхөх, эргүүлэн татах.</p>	<p>Хуулийн төсөлд тодорхойлсон баялгийн санд хориглох үйл ажиллагааны төрлүүдийг хамрах хүрээний хувьд хэт явцуу тодорхойлсон байна. Иймд баялгийн сангийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалтын бусаар ашиглаж болох бүх нөхцөлийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.</p>

Эх сурвалж:

1. IWG, Sovereign Wealth Funds Generally Accepted Principles and Practices -Santiago Principles, IWG Publishing (2008).
2. Монгол Улсын Их Хурлын тогтоол, № 23, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай, 2020.
3. Монгол Улсын Их Хурлын тогтоол, № 56, Монгол Улсын Хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай, 2021.

Хуулийн шүүмжийг боловсруулсан:  
Хууль зүйн доктор. М.Түвшинжаргал (Ph.D., Erciyes),  
ННФ-ын Төсвийн зөвлөл



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Жамъян гүний гудамж-5/1  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар-14240  
Монгол Улс  
Утас: (976) 76113207  
Вэб: www.forum.mn  
И-мэйл: osf@forum.mn